



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 01 өдөр

Дугаар А/153

Сүхбаатар сум

### Жендерийн эрх тэгш байдлыг хангах аймгийн салбар хороог шинэчлэн байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 "а", Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Жендерийн эрх тэгш байдлыг хангах аймгийн салбар хорооны бүрэлдээхүүн"-ийг нэгдүгээр, "Жендерийн эрх тэгш байдлыг хангах аймгийн салбар хорооны ажиллах журам"-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2."Жендерийн эрх тэгш байдлыг хангах аймгийн дэд хөтөлбөр"-ийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, тайланг жил бүр тайлагнаж ажиллахыг салбар хорооны дарга, аймгийн Засаг даргын орлогч /Б.Нарантуяа/-д даалгасугай.

3.Төлөвлөгөөний зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг аймаг, сумын жил бүрийн төсөвт тусгаж гадаад, дотоодын болон хувийн хэвшлийн байгууллагын хөрөнгө оруулалтыг татан оролцуулах, Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, арга хэмжээний төлөвлөгөөг өөрийн эрхлэх асуудлын хүрээ, харьяа нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг хэлтэс, албадын дарга болон сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2017 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/46 тоот захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



ШОРГИЛ

Сэлэнгэ аймгийн Засаг даргын  
2019 оны 05 -р сарын 01 -ны өдрийн  
А/153 тоот захирамжийн 1 хавсралт

ЖЕНДЕРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ АЙМГИЙН САЛБАР  
ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Салбар хорооны дарга

-Аймгийн Засаг даргын орлогч

Салбар хорооны дэд дарга

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга

-АЗДТГ-ын Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн  
хамгаалал, даатгал, жендерийн бодлогын  
асуудал хариуцсан мэргэжилтэн

Гишүүд:

-Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний  
газрын дарга

✓-Аймгийн Эрүүл мэндийн газрын дарга –

✓-Аймгийн Боловсрол соёл урлагийн газрын –  
дарга

-Аймгийн Биеийн тамир, спортын газрын дарга

✓-Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн  
газрын дарга

-Аймгийн Статистикийн хэлтсийн дарга

-Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга

-Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар

-Аймгийн Цагдаагийн газрын дарга

-Сэлэнгэ аймаг дахь Хүний эрхийн комиссын  
ахлах мэргэжилтэн /тохиролцсоноор/